

НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ




Нийгмийн даатгал, халамж үйлчилгээтэй холбоотой бэрхшээл нийт судалгаанд оролцогчдын 9,6 хувь буюу 156 иргэнд ямар нэг байдлаар тохиолдсон байна. Тохиолдож буй бэрхшээлийн төрлийг дараах графикаас харна уу.

6.4% Жирэмсний болон амаржсаны тэтгэмжээ авч чадахгүй байх

8.3% Нийгмийн даатгалын сангаас тэжээгч болон хөдөлмөрийн чадвараа алдсаны, ажилгүйдлийн, гэнэтийн ослын, оршуулгын гэх мэт тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ авч чадахгүй байх

13.5% Хөгжлийн бэрхшээлээ тогтоолгож тэтгэмжээ авч чадахгүй байх




36.5% Хүний хөгжлийн сангийн мөнгө, хүүхдийн мөнгө, оюутны тэтгэлэг гэх мэт хөтөлбөрт хамрагдаж чадахгүй байх


19.2% Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ, тусламж авч чадахгүй байх

16.1% Өндөр насны тэтгэвэр тогтоолгох, хугацаа тооцуулж чадахгүй байх


Энэ төрлийн бэрхшээл аймгийн төвд илүү тохиолдож байна гэж хариулжээ.



■ Нийслэлд



■ Аймгийн төвд




■ Сумдад

Энэ төрлийн бэрхшээл нь гэр хорооллын, орлого багатай, олон ам бүлтэй иргэдэд хамгийн түгээмэл тохиолддог байна. Орлого, амьдралын орчин, ажил эрхлэлт, боловсролын байдлаар харуулбал:

35,3% Бүрэн дунд боловсролтой

50,6% 4-5 ам бүлтэй

77,5% Гэр хороололд гэр, байшинд амьдардаг




Өрхийн орлого нь 500.000 төгрөгөөс доош **59%**


Ажилгүй **33,3%**

Тэтгэвэрт **17,9%**

Бэрхшээлтэй тулгарсан иргэдийн тал хувь нь шийдвэрлэх талаар ямар нэг оролдлого хийсэн байна. Оролдлого хийгээгүй иргэдийн шалтгааныг авч үзвэл:



Энэ төрлийн бэрхшээл тулгарсан иргэдийн 60,6 хувь нь энэ асуудлаа шийдвэрлэхийн тулд бусдаас туслалцаа аваагүй бөгөөд хэнд хандаж, ямар туслалцаа авахаа мэдэхгүй, зардал чирэгдэл гарна гэж бодсон байна.



Энэ төрлийн бэрхшээлийн шийдвэрлэлтийн хувь бага байгаа ч иргэд үргэлжүүлэн хөөцөлдсөөр байдаг нь дараах графикаас харагдаж байна.



Хөөцөлдөхөө больж орхисон шалтгааны харвал “Цаашаа хэрхэн шийдвэрлэхээ мэдэхгүй байсан” гэж 44.4 хувь нь хариулжээ.

АСУУЛТ

- Энэ дүр зураг бодит байдалтай нийцэж байна уу?
- Иргэдэд нийгмийн даатгал, халамж үйлчилгээтэй холбоотой эрх, боломжийн талаар ямар мэдээллийг нэн түрүүнд хүргэх шаардлагатай вэ?
- Дээрх мэдээллийг ямар сувгаар хүргэвэл илүү үр дүнтэй вэ?